



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙГЭЭС 444.5 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГО
ТӨВЛӨРӨӨГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: АРА-2025/27-ШТА-ГА

Архангай аймаг 2025 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх
аудитор **Т.Байгалмаа**

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер **Д.Нэргүйбаатар**

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор **П.Цэцэгдулам**

Утас: 99339725 Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn

Аудитор **В.Цогжаргал**

Утас: 99158257 Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn

Аудитор **Н.Энхчимэг**

Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор **А.Пүрэвцэцэг**

Утас: 99746363 Цахим хаяг: Purevtsetsega@audit.gov.mn

Аудитор **Б.Анхтуяа**

Утас: 99412231 Цахим хаяг: Ankhtuyabo@audit.gov.mn

Аудитор **Б.Азантунгалаг**

Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn



Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Архангай аймаг дахь	Товчилсон үгийн тайлбар.....	4
Төрийн аудитын	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
газар	Үндсэн мэдээлэл	6-8
Тэргүүлэх аудитор	БҮЛЭГ А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БАЙГУУЛЛАГА БҮРЭЭР УРЬДЧИЛАН ТООЦОЖ, БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА	6-8
Т.Байгалмаа	<i>А.1 Хүү торгуулийн орлогыг төлөвлөхийг хуулиар тодорхойлсон тул төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцэж байна</i>	6-8
Аудитын менежер	<i>А.2 Торгуулийн орлогыг орлого төвлөрүүлэгч байгууллагын санал, гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна</i>	6-8
Д.Нэргүйбаатар	<i>А.3 Хүү, торгуулийн орлогыг хуульд заасны дагуу төлөвлөж байна</i>	6-8
Ахлах аудитор	БҮЛЭГ Б. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙГ БҮРЭН ТӨЛҮҮЛЭХ ТАЛААР АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙГЭЭС ТӨСӨВТ 444.5 САЯ ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	8-15
П.Цэцэгдулам	<i>Б.1 Цагдаагийн газар, байгаль орчны газраас хууль, журмын дагуу ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.</i>	8-15
Аудитор	<i>Б.2 Торгуулиас бүрдсэн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд хуваарилахдаа зарим сумд хуульд заасан хувь, хэмжээг баримтлаагүй байна</i>	8-15
В.Цогжаргал	БҮЛЭГ В. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮНГ ШУУД ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА	15-19
Б.Анхтуяа	<i>В.1 Торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна</i>	15-19
Н.Энхчимэг	<i>В.2 Торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна</i>	15-19
А.Пүрэвцэцэг	БҮЛЭГ Г. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА	19-21
Б.Азантунгалаг	<i>Г.1 Байгууллага хооронд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сангүй байна</i>	19-21
2025 оны 08 дугаар	<i>Г.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэлд аймгийн ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна</i>	19-21
сар	<i>Дүгнэлт.....</i>	22
Уг тайланг	<i>Уламжлах санал.....</i>	23
www.audit.mn	<i>Холбогдох байгууллагын санал</i>	24
сайтаас үзнэ үү.	<i>Тайлан баталгаажуулсан тушаал.....</i>	25-26
Аудитын тайлан,		
дүгнэлттэй холбоотой		
асуудлаар нэмж		
тодруулах зүйл		
байвал 7033-2860		
дугаарын утас, 7033-		
3141 дугаарын		
факсаар харилцана		
уу		
Хаяг:		
Эрдэнэбулган		
сум Аймгийн		
ЗДТГ-ын байр		
3-р давхар 314 тоот		



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсвийн орлогын ангилал /2023, 2024 оноор/	5
Хүснэгт 2	Аймгийн 2023-2025 оны хүү, торгуулийн орлогын төсвийн санал	7
Хүснэгт 3	Аймгийн 2022-2025 оны хүү, торгуулийн орлогын төлөвлөлт	7
Хүснэгт 4	Хүү, торгуулийн орлогын 2023-2024 оны ногдуулалт, төвлөрүүлэлт	9
Хүснэгт 5	Торгуулийн орлогын үлдэгдэл	10
Хүснэгт 6	Эрх бүхий албан тушаалтны тоо	11
Хүснэгт 7	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (аймаг, сумдаар)	12
Хүснэгт 8	Орлого төвлөрүүлэл (улс, орон нутгаар)	13
Хүснэгт 9	Орлогын тулгалт	14
Хүснэгт 10	Торгуулийн орлогын судалгаа	14
Хүснэгт 11	Гэмт хэргийн зардалд хуваарилагдсан дүн	15
Хүснэгт 12	Гэмт хэргийн зарцуулалт хуулийн заалтаар	16
Хүснэгт 13	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	17
Хүснэгт 14	Шилэн дансанд мэдээлсэн байдал	19
Хүснэгт 15	Цагдаагийн газрын торгууль төлсөн хэлбэр	20

График, дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Орлого төвлөрүүлэгч байгууллагаар	10
График 2	Аймгийн 2022-2024 оны гэмт хэргийн үзүүлэлт	18



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймгийн орон нутгийн төсвийн хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Нийслэлийн Төрийн аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх;
- Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх;
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумын 2023, 2024 оны хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт материал болон түүнд хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг хамруулж, аудитыг арга зүйн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Зөрчлийн тухай хууль 2017 онд батлагдсанаар ямар үйлдэл, эс үйлдэхүй зөрчил болохыг Захиргааны хариуцлагын тухай хуулиас гадна 230 гаруй хуулиар зохицуулдаг байсныг нэгтгэн энэ хуулиар зохицуулсан байна.

Энэ хуулийн тусгай ангид шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулах хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх



хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна гэж заасан.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт "... хүү, торгуулийн орлого" нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

Орон нутгийн төсөвт торгуулийн орлого төвлөрүүлдэг аймгийн болон 19 сумын төсөвт байгууллагын нийт 62 данс байна. Сумдын дансанд төвлөрсөн торгуулийн орлогыг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд тусгаж, нийт дүнгээр төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж байна. Дансны ерөнхий ангиллыг харуулбал:

- 952 – Ар.Татварын торгууль
- 956 – Ар.Татварын алданги
- 985 – Ар.ЦХ-ийн хүү торгуулийн орлого
- 987 – Ар.ЗЦ-ийн хүү торгуулийн орлого
- 988 – Ар.Хүү торгуулийн орлого

Аймгийн хэмжээнд 2023-2024 онд нийт 54,719.7 сая төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд үүний 3,326.5 сая төгрөг нь хүү, торгуулийн орлого байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1. Төсвийн орлогын ангилал /2023, 2024 оноор/

(сая төгрөгөөр)

Төсвийн орлогын ангилал	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын орлого	16,274.2	18,778.9	2,504.9	22,032.0	28,774.8	6,742.8
Татварын бус орлого	3,536.2	2,841.4	(694.8)	2,528.1	4,078.1	1,550.0
Хөрөнгийн орлого	50.0	116.4	66.4	32.8	130.1	97.3
Нийт орлого	19,860.2	21,736.7	1,876.5	24,592.9	32,983.0	8,390.1
Торгуулийн орлого	1,005.0	1,546.2	541.2	1,176.4	1,712.3	530.9
Хүүгийн орлого	1,945.9	68.0	(1,877.9)	508.6	-	(508.6)

Эх сурвалж: (Сангийн яам)

Хүснэгтээс харахад аймгийн төсвийн татварын бус орлогын 28.4-46.7 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Дээрх орлого 2023 онд 1,005.0 сая мянган төгрөг байсан бол 2024 онд 1,176.4 сая төгрөг болж 17.5 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд нийт 23 байгууллагын 208 эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэж байгаа бөгөөд 2023-2024 онд нийт 2,787.1 сая төгрөгийн торгууль оногдуулснаас 18 байгууллага орон нутгийн төсөвт 2,209.2 сая, 4 байгууллага улсын төсөвт 69.2 сая, Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын санд 14.6 сая төгрөгийн торгуулын орлого төвлөрүүлж 494.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.



БҮЛЭГ А. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ БАЙГУУЛЛАГА БҮРЭЭР УРЬДЧИЛАН ТООЦОЖ, БОДИТОЙ ТӨЛӨВЛӨХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

А.1 Хүү торгуулийн орлогыг төлөвлөхийг хуулиар тодорхойлсон тул төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцэж байна

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д “Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ” 23.7.2-т “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, **хүү, торгуулийн орлого**”, 23.9-д “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ” 23.9.2-д “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, **хүү, торгуулийн орлого**”-оос бүрдэнэ гэж тус тус заасан.

Түүнчлэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1¹-д заасны дагуу торгуулийн орлогын тодорхой хувь нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын эх үүсвэр болон хуваарилагддаг бол Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу орон нутгийн авто замын сангийн хөрөнгийн нэг эх үүсвэр нь “орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль”-ийн орлого байхаар хуульчилсан.

Архангай аймгийн хэмжээнд дээрх хуулийн зохицуулалтын дагуу торгуулийн орлогыг 2023 онд 1,546.2 сая, 2024 онд 1,712.3 сая төгрөгөөр төлөвлөж аймаг, сумын ИТХ-аар батлуулсан бөгөөд торгуулийн орлогоос аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023 онд 216.3 сая төгрөг, 2024 онд 338.3 сая төгрөгийг зарцуулжээ. Харин авто замын сангийн эх үүсвэрт 2023 онд 650.0 сая төгрөг, 2024 онд 727.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

А.2 Торгуулийн орлогыг орлого төвлөрүүлэгч байгууллагын санал, гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.3 дах хэсэгт “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, **торгуулийн орлого**, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ” гэж заасан байна.

Үүний дагуу хүү, торгуулийн орлогыг аймгийн хэмжээнд 2023-2024 онд дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:



Хүснэгт №2 Аймгийн 2023-2025 оны хүү, торгуулийн орлогын төсвийн санал

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Он	Орон нутгаас хүргүүлсэн санал		Сангийн Яам хянасан		Аймгийн ИТХ-аар баталсан
		Суурь орлого	Нийт орлого	Суурь орлого	Нийт орлого	
Хүүгийн орлого	2023	-	-	2,097.9	2,097.9	2,097.9
	2024	-	-	508.7	508.7	508.7
	2025	-	-	444.8	444.8	444.8
Торгуулийн орлого	2023	700.0	700.0	900.0	900.0	1,005.0
	2024	1,176.4	1,176.4	1,176.4	1,176.4	1,176.4
	2025	1,196.1	1,196.1	1,200.0	1,200.0	1,200.0

Хүүгийн орлогын тухайд:

Дээрх төлөвлөлтөөс харахад 2023-2024 онд орон нутгаас хүргүүлсэн төсвийн саналд хүүгийн орлогыг төлөвлөөгүй бөгөөд Сангийн яамнаас Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлттэй холбоотой хүүгийн орлогыг 2023 онд 2,097.9 сая, 2024 онд 508.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна.

Торгуулийн орлогын тухайд:

Орон нутгаас торгуулийн орлогыг 2023 онд 700.0 сая, 2024 онд 1,176.4 сая, 2025 онд 1,196.1 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлсэн саналыг Сангийн яамнаас 2023 онд 200.0 сая, 2025 онд 3.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан бол 2024 онд орон нутгийн саналаар хянасан байна. Аймгийн хэмжээний торгуулийн орлогыг 2023 онд 1,005.0 сая, 2024 онд 1,176.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2023 онд 1,546.2 сая, 2024 онд 1,712.3 сая төгрөг төвлөрүүлж орлого 45.5-53.8 хувиар буюу 535.9-541.2 сая төгрөгөөр давж биелсэн байна. Торгуулийн орлогын 2022-2025 оны төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №3 Аймгийн 2022-2025 оны торгуулийн орлогын төлөвлөлт

(сая төгрөгөөр)

Он	Өмнөх оны гүйцэтгэл	Төсвийн санал	Батлагдсан төлөвлөгөө	Зөрүү	
1	2	3	4	5=3-2	6=4-2
2022	1,198.4	-	-	-	
2023	1,546.2	700.0	1,005.0	-498.4	-193.4
2024	1,712.3	1,176.4	1,176.4	-369.8	-369.8
2025	-	1,196.1	1,200.0	-516.2	-512.3

Хүснэгтээс үзэхэд 2022-2025 оны торгуулийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс 369.8-516.2 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн буюу гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүй харагдаж байна.

Гэсэн хэдий ч өмнөх оны төлөвлөгөөгүй торгуулийн үлдэгдлээс тухайн онд төлөгдсөнөөр тайлант оны гүйцэтгэлийг нэмэгдүүлжээ. **Тухайлбал:** Аймгийн Цагдаагийн газар нь 2023-2024 онд нийт 2,050.1 сая төгрөгийн торгууль оногдуулснаас, гүйцэтгэлээр 1,613.2 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлсний 821.9 сая төгрөг нь тайлант оноос, 791.3 сая төгрөг нь өмнөх оноос төвлөрсөн байна.



Иймд торгуулийн орлого нь урьдчилан тооцож бодиттой төлөвлөх боломжгүй, тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалдаг тул дийлэнх орлогыг төвлөрүүлж байгаа байгууллагын саналд үндэслэн төлөвлөдөг байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зөрчил шалган шийдвэрлэх 23 байгууллагаас Цагдаа, Татварын газраас бусад нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-т “хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй” гэж заасны дагуу торгуулийн орлого төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн дагуу аймаг, сумдын тухайд торгуулийн орлогыг төлөвлөх шаардлагатай ч хэт өндөр, бодитой бус төлөвлөх нь хууль сахиулж байгаа эрх бүхий албан тушаалтныг орлого төвлөрүүлэгч болгох, хууль сахиулах үндсэн зорилгыг алдагдуулах, ашиг сонирхлын зөрчил үүсгэх, иргэдэд торгуулийн дарамт учруулах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй юм.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын сан тус бүрийн орлогын зарцуулагдаагүй үлдэгдлийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох дансанд сар бүр төвлөрүүлнэ” гэж заасны дагуу төвлөрүүлдэг бөгөөд аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2023, 2024 онд хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна.

А.3 Хүү, торгуулийн орлогыг хуульд заасны дагуу төлөвлөж байна

Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт нь Төсвийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” зэрэг хууль, журмаас гадна тухайн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын салбарын хууль, журам, аргачлалуудаар зохицуулагдаж байна. *Тухайлбал:* Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын салбарын харъяалал, эдгээр нь Зөрчлийн тухай хуульд заасан ямар зөрчилд торгууль оногдуулах талаар дэлгэрэнгүй тусгаж өгсөн бөгөөд үүний дагуу торгууль оногдуулж байгаа нь холбогдох хуульд заасан шаардлагад нийцсэн гэж үзэж байна.

Харин оногдуулсан торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар үр дүнтэй, арга хэмжээ авч ажиллахгүй байгаа нь орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Орлого бүрдүүлэлтийн талаар тайлангийн 2-р бүлэгт дэлгэрэнгүй тусгалаа.

БҮЛЭГ Б. НОГДУУЛСАН ТОРГУУЛИЙГ БҮРЭН ТӨЛҮҮЛЭХ ТАЛААР АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙГЭЭС ТӨСӨВТ 444.5 САЯ ТӨГРӨГИЙН ТӨВЛӨРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

Б.1 Цагдаагийн газар, Байгаль орчны газраас хууль, журмын дагуу ногдуулсан торгуулийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.



Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дэхь заалтад “...хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум дүүрэг орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан байна.

Аймгийн хэмжээний хүү, торгуулийн орлогын төвлөрүүлэлтийг сүүлийн 2 жилээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №4 Хүү, торгуулийн орлогын 2023-2024 оны ногдуулалт, төвлөрүүлэлт
(сая төгрөгөөр)

Он	Хүүгийн орлого			Торгуулийн орлого		
	Ногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү	Ногдуулсан	Төвлөрсөн	Зөрүү
2023 он	1,945.9	111.9	(1,834.0)	1,520.3	694.2	826.1
2024 он	508.6	57.1	(451.5)	1,254.4	808.9	445.5
ДҮН	2,454.5	169.0	(2,285.5)	2,774.7	1,503.1	1,271.6

Эх сурвалж: (Аудитын нэгдсэн судалгаа)

Аймгийн хэмжээнд 2023-2024 онд нийт 169.0 сая төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн байна.

- Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ, 2004-2010 онуудад нийтийн аж ахуйг сайжруулах төслийн хүрээнд Азийн хөгжлийн банк, Засгийн газар хоорондын дамжуулан зээлийн эргэн төлөлтийн хүүг Сангийн яамнаас орон нутгийн суурь орлогод нэмж хянасантай холбоотой хүүгийн орлого төлөвлөгдсөн байна. “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын жил дараалан алдагдалтай ажиллаж 2,454.5 сая төгрөгийн зээлийн хүүгийн төлбөрөөс 68.0 сая төгрөгийг төлж, хүүг бүрэн төлөөгүйгээс төлөвлөгдсөн хүүгийн орлого тасарсан байна.
- Нийгмийн даатгал газар нь тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэлд тооцогдсон нийт 101.0 сая төгрөгийн хүүг санд нь төвлөрүүлсэн байна. Харин хүүгийн орлого төлөвлөдөггүй байна.

Торгуулийн тухайд:

Аймгийн хэмжээнд 2023-2024 онуудад нийт 19 байгууллагаас 80577 зөрчилд 2,774.7 сая төгрөгийн торгууль ногдуулснаас гүйцэтгэлээр 1,503.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, тайлант хугацааны эцэст 1,271.6 сая төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлтэй байв. Тухайн онд ногдуулсан торгуулийн орлого жил дамнан төлөгдөж байгаагаас 2025 оны 6 сарын байдлаар төлөгдөөгүй байгаа торгуулийн үлдэгдэл 487.1 сая төгрөг болсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 Торгуулийн орлогын үлдэгдэл

(сая төгрөгөөр)

№	Утга	Он		Дүн
		2023	2024	
1	Зөрчлийн тоо	44016	36561	80577
2	Тайлант онд ногдуулсан дүн	1,520.30	1,254.40	2,774.70
3	Тайлант оны ногдуулалтаас төвлөрүүлсэн дүн	694.2	808.9	1,503.10
4	2024 онд төвлөрсөн	470.5	-	470.5
5	2025 онд төвлөрсөн	114.8	199.2	314
6	Төвлөрөөгүй дүн	240.8	246.3	487.1



6.1	Үүнээс:	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	10.3	32.3	42.6
6.2		Хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй	230.5	214	444.5

- **2023 оны тухайд:** Нийт 1,520.3 сая төгрөгийн торгууль ногдуулснаас тухайн онд 694.2 сая, 2024 онд 470.5 сая, 2025 оны эхний хагас жилд 114.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 240.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- **2024 оны тухайд:** Нийт 1,254.4 сая төгрөгийн торгууль ногдуулснаас тухайн онд 808.9 сая, 2025 оны эхний хагас жилд 199.2 сая төгрөгийг төвлөрүүлж, 246.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

График №1 Орлого төвлөрүүлэгч байгууллагаар
(сая төгрөгөөр)

Нийт төвлөрүүлсэн 1,503.1 сая төгрөгийн орлогын 55.6 хувийг Цагдаагийн газар, 28.8 хувийг Татварын газар, 15.6 хувийг бусад байгууллага төвлөрүүлсэн байна.

Аудитаар нийт 487.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 42.6 сая төгрөгийг төлүүлэхээр хууль хяналтын байгууллагад

шилжүүлсэн байна. Харин Аймгийн Цагдаагийн газар нь 436.9 сая, Байгаль орчны газар нь 7.6 сая төгрөг нийт 444.5 сая төгрөгийг төлүүлэх арга хэмжээ аваагүй төвлөрүүлээгүй байна. Энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1¹ дэх хэсэг, 8² дахь хэсэг, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/42, А/71 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал"-ын 2.4³-т дахь заалтыг зөрчиж байна.



Иймд аудитаас орлогыг бүрэн төвлөрүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчны газрын удирдлагуудад хүргүүлээ.

Зөрчлийн тухай хуультай уялдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай

¹ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: "Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна"

² "Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана"

³ Энэ аргачлалын 2.2-т заасан хугацаа дуусмагц эрх бүхий албан тушаалтан дараах шийдвэрийг гаргаж, харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ: Үүнд 2.4.2-т "Хүнд оногдуулсан торгох шийтгэл, нэмэгдүүлэн тооцсон төлбөрийн нийлбэр нь 450 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс доош бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэх хүсэлт



хуулийг баталсан байна. Тус хуулийн 1.8 дугаар зүйлийн 1.8.6 дахь заалтад эрх бүхий албан тушаалтан бүрээр шалган шийдвэрлэх зөрчлийг тодорхой заасан.

Аймгийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх 23 байгууллагын 208 эрх бүхий албан тушаалтан байна. Тэдгээрээс 2023 онд 44016 зөрчилд 1,520.3 сая, 2024 онд 36561 зөрчилд 1,254.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Прокурорын байгууллагаас зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлдэг⁴ тул эрхгүй албан тушаалтан торгууль тавих боломжгүй байна.

Торгууль ногдуулах эрх бүхий албан тушаалтныг байгууллага тус бүрээр, аймаг, сумаар хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 Эрх бүхий албан тушаалтны тоо

№	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	ЭБАТ-ны тоо	
		Аймаг	Сум
1	Аймгийн Засаг даргын тамгын газар	10	-
2	Цагдаагийн газар	22	48
3	Онцгой байдлын газар	2	-
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2	-
5	Татварын газар	20	13
6	Улсын бүртгэлийн хэлтэс	1	-
7	Байгаль орчны газар	3	17
8	Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар	2	-
9	Боловсролын газар	1	-
10	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуудын газар	2	-
11	Эрүүл мэндийн газар	4	-
12	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	2	-
13	Стандарт хэмжилзүйн хэлтэс	2	-
14	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	4	-
15	Авто тээврийн төв	1	-
16	Орхон, Чулуут голын сав газрын захиргаа	1	-
17	Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа	2	-
18	Архангай аймаг дахь Монгол банкны салбар	3	-
19	Статистикийн хэлтэс	2	-
20	Нийгмийн даатгалын газар	12	6
21	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	2	-
22	Мал эмнэлгийн газар	3	17
23	Хүнс, хөдөө аж ахуйн газар	4	-
ДҮН		107	101

Дээрх байгууллагуудаас Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуудын газар нь 2023-2024 онд огт торгууль ногдуулаагүй байна.

⁴ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1.1.зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах



Аймгийн хэмжээнд 2023-2024 оны торгуулийн орлогыг 2,186.4 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 3,258.5 сая төгрөг төвлөрүүлэн, орлого 49.0 хувиар буюу 1,072.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (аймаг, сумдаар)

№	Нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Тариат	10.0	27.7	17.7	10.0	6.9	(3.1)
2	Хайрхан	3.0	11.0	8.0	3.0	8.1	5.1
3	Хашаат	115.8	247.5	131.7	150.0	168.5	18.5
4	Цэнхэр	10.0	21.4	11.4	10.0	13.4	3.4
5	Ихтамир	10.0	75.3	65.3	30.0	46.7	16.7
6	Өгийнуур	3.9	10.6	6.7	3.3	4.0	0.7
7	Жаргалант	4.3	8.5	4.2	5.0	3.7	(1.3)
8	Хотонт	8.2	11.2	3.1	14.2	16.8	2.6
9	Цахир	2.0	2.8	0.8	7.5	7.7	0.2
10	Төвшрүүлэх	7.6	7.3	(0.3)	7.0	6.6	(0.4)
11	Эрдэнэбулган	350.0	328.3	(21.7)	380.0	347.5	(32.5)
12	Өндөр-Улаан	3.5	27.9	24.4	15.0	11.2	(3.8)
13	Чулуут	1.0	14.6	13.6	10.0	3.1	(6.9)
14	Эрдэнэмандал	4.0	22.0	18.0	4.0	7.4	3.4
15	Өлзийт	0.5	15.3	14.8	4.2	20.3	16.1
16	Цэцэрлэг	1.0	4.4	3.4	1.3	1.3	0.0
17	Хангай	1.0	4.9	3.9	1.7	2.3	0.6
18	Батцэнгэл	4.0	11.6	7.6	4.0	1.2	(2.8)
19	Булган	0.3	0.9	0.6	0.6	0.4	(0.2)
20	Аймаг	465.0	692.8	227.8	515.6	1,035.2	514.6
Дүн		1,005.0	1,546.2	541.2	1,176.4	1,712.3	530.9

Дээрх хүснэгтээс харахад аймгийн орлого нийт дүнгээр давж биелсэн боловч 2023 онд 2 сум 22.0 сая, 2024 онд 6 сум 51.0 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Аймгийн Цагдаагийн газар нь 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 29/1503 тоот албан бичгийг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд хүргүүлж 19 сумын хэв журмын цагдаа, цагдаагийн бэлэн бус торгуулийн төхөөрөмжийн орлогын дансыг аймгийн торгуулийн данстай холбосоноос сумын төсөвт орох торгуулийн орлого аймгийн төсөвт төвлөрч 2024 онд 8 сумын орлого тасрахад нөлөөлсөн байна.

Төвлөрүүлсэн орлогыг төсвийн ангилалаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №8 Орлого төвлөрүүлэлт (улс, орон нутгаар)

№	Утга	Он		Дүн
		2023	2024	
1	Тайлант онд төвлөрүүлсэн нийт дүн	1,592.3	1,737.6	3,329.9
1.1	Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн	46.1	25.3	71.4
1.2	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн дүн	1,546.2	1,712.3	3,258.5
1.2.1	Үүнээс:	Өмнөх онуудын ногдуулалтаас		1,971.7
1.2.2		Тайлант оны ногдуулалтаас		1,286.8



- 2023 онд төвлөрсөн 1,546.2 сая төгрөгийн орлогын 41.0 хувь буюу 634.5 сая төгрөг нь тайлант оны ногдуулалтаас төвлөрсөн бол 59.0 хувь буюу 652.3 сая төгрөг нь өмнөх онуудад ногдуулсан торгуулийн орлого байна.
- 2024 онд төвлөрсөн 1,712.3 сая төгрөгийн орлогын 38.1 хувь буюу 652.3 сая төгрөг нь тайлант оны ногдуулалтаас төвлөрсөн бол 61.9 хувь буюу 1,060.0 сая төгрөг нь өмнөх онуудад ногдуулсан торгуулийн орлого байна.

Харин Зөрчлийн тухай 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлнэ” гэж тусгасан байна. Үүнтэй холбоотой аймгийн хэмжээнд 2023 онд 13.6 сая, 2024 онд 131.3 сая төгрөгийн торгуулийг хөнгөрүүлж, нийт 1,358.2 сая төгрөг төвлөрсөн байна.

Аймгийн хэмжээнд 2023-2024 онуудад ногдуулсан торгуулиас төвлөрсөн 1,358.2 сая төгрөгийн 5.3 хувь буюу 71.4 сая төгрөгийг улсын төсөвт, 94.7 хувь буюу 1,286.8 сая төгрөг нь орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

- Нийгмийн даатгалын газар нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.7-д “...Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийн төлбөрийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлнэ” гэж заасны дагуу торгуулийн орлогыг төвлөрүүлж байна.
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Статистикийн хэлтэс, Мал эмнэлгийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, ЗДТГ-ын Архивын тасаг зэрэг байгууллагууд торгуулийн орлогыг ерөнхий газрын чиглэлийн дагуу улсын төсөвт төвлөрүүлж байна.

Дээрх байгууллагуудын торгуулийн орлого улсын төсөвт төвлөрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалттай нийцэхгүй байна. Иймд Төсвийн тухай хуулийн дагуу торгуулийн орлогыг төвлөрүүлэхэд нэгдсэн арга хэмжээ авч ажиллах саналыг уламжилж байна.

Торгуулийн орлогын дансны хуулгаар орсон орлогыг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлагнасан орлоготой харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №9 Орлогын тулгалт

(сая төгрөгөөр)

Он	Дансны хуулгаарх орлого	Тайлангаарх орлого	Зөрүү
2023	1,557.4	1,546.2	11.2
2024	1,716.9	1,712.3	4.6
Дүн	3,274.3	3,258.5	15.8

2023-2024 онд дансны хуулгаар нийт 3,274.3 сая төгрөгийн орлого төвлөрч, 15.8 сая төгрөгийн гүйлгээг залруулж, 3,258.5 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Торгуулийн орлого төвлөрүүлэх дансыг аймаг, сумдын, татварын, цагдаагийн гэж байгууллагаар ангилсан боловч дансанд төвлөрч байгаа орлого нь ямар байгууллагын оногдуулсан торгууль төлөгдөж байгаа нь тодорхой бус, нэхэмжлэхийн дугаараар төлөгдөж байна.



Энэ нь орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллага бүрээр гаргах боломжгүй байдал бий болж, хяналт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа тул энэхүү асуудлыг анхаарч, арга хэмжээ авч ажиллах саналыг уламжиллаа.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд торгуулийн орлогыг дараах байдлаар тайлагнасан байна.

Хүснэгт №10 Торгуулийн орлогын судалгаа

(сая төгрөгөөр)

Орлогын нэр төрөл	2023 он				2024 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Эзлэх хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Эзлэх хувь
Нийт орлого	19,860.2	21,736.7	1,876.5	100.0%	24,592.9	32,983	8,390.1	100.0%
Татварын бус орлого	3,536.2	2,841.4	(694.8)	13.1%	2,528.1	4,078.1	1,550.0	12.4%
Торгуулийн орлого	1,005.0	1,546.2	541.2	54.4%	1,176.4	1,712.3	530.9	42.0%
Нийт орлогод торгуулийн орлогын эзлэх хувь				7.1%	Нийт орлогод торгуулийн орлогын эзлэх хувь			5.2%
Татварын бус орлогод торгуулийн эзлэх хувь				54.4%	Татварын бус орлогод торгуулийн эзлэх хувь			42.0%

Эх сурвалж: (Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Аймгийн торгуулийн орлогын гүйцэтгэл 2023 онд 1,546.2 сая төгрөг бөгөөд нийт орлогын 7.1 хувийг, татварын бус орлогын 54.4 хувийг эзэлсэн байна. Харин 2024 онд 1,712.3 сая төгрөг болж, нийт орлогын 5.2 хувийг, татварын бус орлогын 42.0 хувийг бүрдүүлж байгаа нь торгуулийн орлого нь орлогын бусад эх үүсвэрт нөлөөлж байна.

Б.2 Торгуулиас бүрдсэн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд хуваарилахдаа зарим сумд хуульд заасан хувь, хэмжээг баримтлаагүй байна

Хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг орлогын нэг төрөл бөгөөд эдгээр орлогыг хуваарилах чиг үүрэг нь аймгийн хувьд төсвийн ерөнхийлөн захирагч, сумдын хувьд төсвийн төвлөрүүлэн захирагч байна.

Торгуулийн орлогоос Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2023-2024 онд 603.3 сая төгрөг хуваарилсан байна. Зардлын хуваарилалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11 Гэмт хэргийн зардалд хуваарилагдсан дүн

(сая.төгрөгөөр)

Ангилал	Он	Өмнөх оны торгуулийн орлогын гүйцэтгэл	Үүнээс:	Хуваарилсан дүн	Хувь
			Гэмт хэргийн зардалд хуваарилах дүн /40 хувь/		
Сум	2023 он	543.7	217.5	170.7	31.4
	2024 он	853.2	341.5	203.6	23.9
Аймаг	2023 он	654.7	261.9	94.6	14.4
	2024 он	692.8	277.1	167.3	24.1
ДҮН		2,744.4	1,098.0	636.2	23.2



Дээрх хүснэгтээс харахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2023-2024 онд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилт нь өмнөх онуудад төвлөрүүлсэн торгуулийн орлогын 23.2 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл хуульд заасан хувь хэмжээнээс 2023 онд 214.1 сая, 2024 онд 247.7 сая төгрөгөөр бага хуваарилсан байна. Харин 2024 онд Цэнхэр, Цахир, Чулуут, Булган сумд гэмт хэргийн зардалд хуульд заасан хувь хэмжээнээс өндөр хуваарилсан нь сумын давсан орлогыг нэмж төлөвлөсөнтэй холбоотой байна.

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ: нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль” гэж заасан. Үүний дагуу авто замын санд 1,377.5 сая төгрөг хуваарилсан байна.

Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаатай уялдан аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа хэрэгждэг бөгөөд аймгийн дараа оны төсөв батлах үед ажлын төлөвлөгөө нь батлагдаагүй байдаг тул гэмт хэргийн зардлыг аймгийн төсөвт “бөөн” дүнгээр баталж байна. Өөрөөр хэлбэл Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам”-д зааснаар Зохицуулах зөвлөлийн тайлан, мэдээ дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор нэгтгэгдэж, ажлын төлөвлөгөөг он гарсны дараа баталдагаас төсөв батлах үед хэрэгжүүлэх ажил нь тодорхой бус байдаг байна. Иймд 2.1-т заасан хугацааг төсвийн тухай хуульд заасан төсвийн төсөл боловсруулах хугацаатай уялдуулан өөрчлөх саналыг уламжиллаа.

БҮЛЭГ В. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР ДҮНГ ШУУД ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА

В.1 Торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан байна

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2023-2024 онд нийт 636.2 сая төгрөг төлөвлөн баталж гүйцэтгэлээр 554.6 сая төгрөгийг зарцуулж 81.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Зарцуулалтыг Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь заалтаар нэгтгэж хүснэгтээр харуулбал: Үүнд

Хүснэгт №12 Гэмт хэргийн зарцуулалт хуулийн заалтаар

(сая төгрөгөөр)

Хуулийн заалт	2023 он		2024 он		Нийт		Хувь
	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Мөнгөн дүн	Ажлын тоо	Мөнгөн дүн	
46.5.1	64	89.5	54	112.5	118.0	202.0	36.4
46.5.2	-	-	-	-	-	-	-
46.5.3	-	-	-	-	-	-	-
46.5.4	13	27.4	15	61.9	28.0	89.3	16.1
46.5.5	2	6.1	1	3.0	3.0	9.1	1.6



46.5.6	-	-	-	-	-	-	-
46.5.7	2	3.0	-	-	2.0	3.0	0.5
46.5.8	3	19.1	3	28.5	6.0	47.6	8.6
46.5.9	9	20.8	2	13.9	11.0	34.7	6.3
46.5.10	2	1.5	3	39.9	5.0	41.4	7.5
46.5.11	56	48.9	71	78.6	127.0	127.5	23.0
Дүн	151	216.3	149	338.3	300.0	554.6	100.0

Хүснэгтээс харахад 2023 онд 8 заалтын хүрээнд давхардсан тоогоор 151 ажилд 216.3 сая, 2024 онд 7 заалтын хүрээнд давхардсан тоогоор 149 ажилд 338.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.2⁵, 46.5.3⁶, 46.5.6⁷ дахь заалтын дагуу хөрөнгө зарцуулаагүй байна.

Аймгийн хэмжээний 2023-2024 оны гэмт хэргийн зардлын нийт зарцуулалтын дийлэнх хэсгийг буюу 75.5 хувийг хуулийн дараах заалтын хүрээнд зарцуулсан байна. Үүнд:

- Хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.1-д “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэдээс иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх”-д, 36.4 хувь буюу 202.0 сая төгрөг,
- Хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.11-д “хууль тогтоомжид заасан бусад” зардалд 23.0 хувь буюу 127.5 сая төгрөг,
- Хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.4-д “гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх”-д 16.1 хувь буюу 89.3 сая төгрөг зарцуулсан байна.

Аймаг сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №13 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл
(сая төгрөгөөр)

№	Сумын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тариат	3.6	3.6	0.0	10.0	10.0	0.0
2	Хайрхан	3.0	2.9	0.1	4.5	2.7	1.8
3	Хашаат	23.5	16.4	7.1	52.7	39.0	13.7
4	Цэнхэр	20.0	18.8	1.2	20.0	19.9	0.1
5	Ихтамир	5.0	3.6	1.4	5.0	4.8	0.2
6	Өгийнуур	1.3	1.2	0.0	2.0	2.0	0.0
7	Жаргалант	5.0	5.0	0.0	0.0	0.0	0.0
8	Хотонт	0.0	0.0	0.0	3.8	3.8	0.0

⁵ 46.5.2.энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;

⁶ 46.5.3.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх

⁷ 46.5.6.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийг хэлэлцүүлэх, хуульд заасан дүрэм, журам, заавар боловсруулах



9	Цахир	2.0	1.9	0.1	2.0	2.0	0.0
10	Төвшрүүлэх	6.8	5.3	1.5	2.8	2.7	0.1
11	Эрдэнэбулган	85.0	49.9	35.1	65.0	63.3	1.7
12	Өндөр-Улаан	2.0	2.0	0.0	10.0	10.0	0.0
13	Чулуут	3.0	3.0	0.0	10.0	2.7	7.3
14	Эрдэнэмандал	3.5	3.5	0.0	5.0	4.9	0.1
15	Өлзийт	0.1	0.1	0.0	1.5	1.5	0.0
16	Цэцэрлэг	0.0	0.0	0.0	1.2	1.2	0.0
17	Хангай	1.0	1.0	0.0	1.5	1.5	0.0
18	Батцэнгэл	3.0	1.4	1.6	3.6	2.6	1.0
19	Булган	3.0	3.0	0.0	3.0	3.0	0.0
Аймаг		79.0	78.0	1.0	150.0	143.5	6.5
Дүн		249.7	200.6	49.1	353.6	321.0	32.6
Цалин, НДШ		15.6	15.6	0.0	17.3	17.3	0.0
ДҮН		265.3	216.3	49.1	370.9	338.3	32.6

Эх сурвалж: (Аймгийн нэгтгэсэн тайлан)

Хүснэгтээс харахад сумдад 2024 онд олгосон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэл өмнөх оноос 122.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь өмнөх оноос аймаг, Эрдэнэбулган, Хашаат, Цэнхэр, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Тариат сумдын гүйцэтгэл нийт 118.4 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.


Аймгийн ИТХ-ын төсөвт батлагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 2023-2024 онд 9 байгууллагад нийт 254.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ. Нийт олгосон санхүүжилтийн 36.2 хувь буюу 92.2 сая төгрөгийг Цагдаагийн газарт, 12.0 хувь буюу 30.6 сая төгрөгийг Прокурорын газарт, 8.5 хувь буюу 21.7 сая төгрөгийг Хүүхэд гэр бүлийн, хөгжил хамгааллын газарт шилжүүлсэн байна. Харин аймгийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын цалин, шимтгэлийн зардал 32.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймаг, сумдын 2023-2024 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээнээс үзэхэд нийт зарцуулалтын 66.1 хувь буюу 366.6 сая төгрөгийг дараах арга хэмжээнүүдэд зарцуулсан байна. Үүнд:

- Бусад төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “иргэдийг гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хуулийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалт, сурталчлагааны ажилд 264.6 сая төгрөг,
- Зам тээврийн осол гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд “Яараад яах вэ дээ”, “Дураараа биш дүрмээрээ” аяныг нэгдсэн болон хэсэгчилсэн хэлбэрээр жил бүр зохион байгуулж нийт 77.8 сая төгрөг,
- Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 2023-2024 онд аймгийн хэмжээнд “Мал мах” нэгдсэн тусгай арга хэмжээнд нийт 24.2 сая төгрөг байна.

Аймгийн хэмжээний 2023-2024 оны гэмт хэргийн байдлыг авч үзвэл нийт гэмт хэрэг 2023 онд 397 хэрэг бүртгэгдсэн ба 2022 оноос 24.2 хувиар буурсан бол 2024 онд 447 хэрэг бүртгэгдсэн ба 2023 оноос 12.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс малын хулгай болон зам тээврийн ослын гэмт хэргийг сүүлийн 3 оноор авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл №2 Аймгийн 2022-2024 оны гэмт хэргийн үзүүлэлт
(тоогоор)



Графикаас харахад мал хулгайлах гэмт хэрэг жил бүр буурсан бол зам тээврийн ослын гэмт хэрэг 2023 онд өмнөх оноос буурсан хэдий ч 2024 онд 74 болж 67.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр дүн муутай байгааг харуулж байгаа ч нөгөө талаас төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдэн, техникийн дэвшил, хяналтын тоног төхөөрөмжийг ашиглах болсон нь далд хэлбэрийн гэмт хэргийг илрүүлэхэд ахиц гарч, илрүүлэлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эх сурвалж: (Аймгийн Нийгэм, эдийн засгийн байдал)

Авто замын сангийн тухайд:

Авто замын сангийн хөрөнгөөр 2023 онд 1,106.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ, 2024 онд 1,273.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Төрийн аудитын байгууллагаас 2023 онд ОНТХО-ын гүйцэтгэлийн аудитаар аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-д захиалагчаас үе шатны хяналтыг хэрэгжүүлэх албан шаардлагын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлснээр бөгөөд 2024 онд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Нэгдсэн эмнэлэг хүртэлх хатуу хучилттай авто зам, зогсоол шинээр тавигдсан бөгөөд иргэд, олон нийт үр ашгийг нь хүртэж байна.

Аудитаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалтай холбоотой зөрчил илрээгүй болно.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 онд батлагдсанаас хойш 8 удаа нэмэлт өөрчлөлт орсон боловч “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах” журам нь 1998 онд батлагдсанаас хойш шинэчлэгдээгүй байгаа тул тухайн журмыг шинэчлэн батлуулахыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх саналыг уламжиллаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсөв нь аймаг болон сумдын ИТХ-ын төсөвт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн /82201/ нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж арга хэмжээ /210801/ зардлын дансанд нийт дүнгээр



баталж зарцуулсан бөгөөд эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулаагүй байна.

В.2 Торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна

Аймаг, сумын ИТХ нь 2023 онд 216.3 сая төгрөг, 2024 онд 338.3 сая төгрөг, нийт 554.6 сая төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд зарцуулжээ. Үүнээс шилэн дансны тухай хуульд заасны дагуу таван сая төгрөөс дээш үнийн дүн бүхий 224.5 сая төгрөгийн 26 гүйлгээг <https://shilendans.gov.mn/> системд бүрэн мэдээлсэн байна.

Хүснэгт №14 Шилэн дансанд мэдээлсэн байдал

(сая төгрөгөөр)

№	Он	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын дүн	5 сая ба түүнээс дээш зардлын гүйлгээний	
			Тоо	Мөнгөн дүн
1	2023 он	216.3	20	185.2
2	2024 он	338.3	6	39.3
Нийт дүн		554.6	26	224.5

Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсэгт “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ” гэж заасан байна. Үүний дагуу 2023-2024 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн фэйсбүүк хуудас, arkhangai.khural.mn сайтаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээлж байна. Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан мэдээлсэн байна.

Иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас хүү торгуулийн орлогын зарцуулалтад үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

БҮЛЭГ Г. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ СУЛ БАЙНА

Г.1 Байгууллага хооронд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сангуй байна

Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэгч 23 байгууллага байгаа бөгөөд байгууллага хоорондын хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын мэдээллийн нэгдсэн сангуй байна. Харин байгууллага бүр салбарын онцлогт нийцсэн бүртгэлийн системийг ашиглаж байна. *Тухайлбал:* Санхүү, төрийн сангийн хэлтэс нь Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн “Фискал” программ, Цагдаагийн газар нь цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн систем, Татварын газар нь “Tais” систем, Нийгмийн даатгалын газар нь “Sigos” системээр мэдээллийн сан бүрдүүлж байна.

Иймд бүртгэлийн нэгдсэн сантай болох чиглэлээр арга хэмжээ авч ажиллах саналыг уламжиллаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд торгох шийтгэлд заасан торгуулийг бэлэн, эсхүл бэлэн бус хэлбэрээр төлнө” гэж заасан бөгөөд зөрчилд холбогдогч нь торгуулийг арилжааны банк, *E-mongolia*, *E-barimt*, *Gerege* болон бусад аппликейшнээр дамжуулан бэлэн ба бэлэн бус хэлбэрээр төлж байна. Тухайлбал: Цагдаагийн газрын торгууль нь дараах хэлбэрээр төлөгдсөн байна. Үүнд:

Хүснэгт №15 Цагдаагийн газрын торгууль төлсөн хэлбэр

(сая.төгрөгөөр)

Торгууль төлсөн хэлбэр	2023 он		2024 он		Нийт мөнгөн дүн
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
E-mongolia	6128	167.4	7240	196.0	363.4
И баримт	143	3.8	21	0.4	4.2
Гэрэгэ	7408	204.3	4580	122.1	326.4
Банк	17223	420.2	10575	239.9	660.1
Бусад аппликейшн	4741	128.9	4596	129.7	258.6
Нийт дүн	35643	924.8	27012	688.3	1,613.1

Хүснэгтээс харахад нийт 1,613.1 сая төгрөгийн торгуулийн орлого төвлөрүүлснээс 41.0 хувь буюу 660.1 сая төгрөгийг банкаар, 59.0 хувь буюу 952.6 сая төгрөгийг *E-mongolia*, *Gerege*, *И-баримт* зэрэг аппликейшнээр төлсөн байна.

Энэ нь ногдуулсан торгуулийг олон төрлийн төлбөрийн хэрэгсэлийг ашиглан хялбар, хурдан шуурхай төлөх боломжтой болсныг харуулж байна.

Байгууллагууд өөрийн салбарын онцлогт тохирсон нэгдсэн мэдээллийн системийг ашигладаг бөгөөд тус системээрээ дамжуулан хяналт хэрэгжүүлж, торгууль тавьсан эрх бүхий албан тушаалтнууд нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу тухайн торгуулийг барагдуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын хэмжээнд нэгдсэн хяналтын систем бүрдээгүй байна.

Г.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэлд аймгийн ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна

Эрх бүхий албан тушаалтан нь шийтгэл оногдуулсан шийдвэрийн биелэлтийг өөрөө хариуцах бөгөөд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр харьяалах шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэхээр байна. Үүний дагуу 6 байгууллага нийт 49.7 сая төгрөгийн төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн торгуулийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Харин Цагдаагийн газар болон Байгаль орчны газар нь хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүйгээс 444.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн торгуулийн үлдэгдэлд арга хэмжээ авч ажиллаагүй байна.



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8-д “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэж заасан байна.

- Төрийн аудитын байгууллагаас жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар аймаг, сумдын ИТХ-ын санхүү төсвийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд 2023 онд 483.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2024 онд 66.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах 4 албан шаардлага, 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож биелэлтийг тооцон ажилласан байна.
- Аймгийн ИТХ 2023-2024 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.

Иймд аймгийн ИТХ-д гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-д “Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтан нь шийдвэрийнхээ биелэлтийг хариуцан ажиллаж байна. Харин эрх бүхий албан тушаалтнуудын зөрчлийн хэрэг үүсгэсэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн зөрчилд Прокурорын байгууллагаас хяналтыг тухай бүр нь хэрэгжүүлэн ажиллаж байна.

Торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хяналт хэрэгжүүлэх этгээдийн сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зарласан боловч 2023-2024 онд иргэд, төрийн бус байгууллагаас энэхүү сонгон шалгаруулалт оролцоогүй байна.

Аудитаар нийт 444.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлээ.



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Хуулийн дагуу хүү, торгуулийн орлогыг төлөвлөх хэрэгцээ шаардлага байгаа хэдий ч үндэслэх тоо, мэдээлэл, судалгаа хангалтгүй байгаагаас бодиттой төлөвлөх боломжгүй байна
- ✓ Аймгийн хэмжээнд 2023-2024 онд 169.0 сая төгрөгийн хүүгийн орлого, 1503.1 сая төгрөгийн торгуулийн орлогыг төвлөрүүлж зарцуулсан байна.
- ✓ Эрх бүхий албан тушаалтнууд хууль журмаар ногдуулсан торгуулийг төлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүйгээс 444.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй үлдэгдэлтэй байна.
- ✓ Торгуулиас бүрдсэн орлогыг хуульд заасан хувь, хэмжээгээр хуваарилаагүй байна.
- ✓ Торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан боловч үр дүнг үнэлэх боломжгүй байна.
- ✓ Зарцуулалтыг шилэн дансны нэгдсэн системээр дамжуулан олон нийтэд ил тод мэдээлсэн байна.
- ✓ Төрийн байгууллагуудын хооронд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлтийн мэдээллийн сан, мэдээлэл солилцох нэгдсэн системгүй байна.
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын гүйцэтгэлд аймгийн ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийн сонгон шалгаруулалтад иргэний нийгмийн байгууллагууд оролцоогүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

**ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС
444.5 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГО ТӨВЛӨРӨӨГҮЙ БАЙНА**



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

Дараах саналуудыг холбогдох байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлж өгнө үү.

1. Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаатай уялдан аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа хэрэгждэг бөгөөд тайлант онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Зохицуулах зөвлөлөөс тухайн онд нь баталдагаас аймгийн төсөв батлахад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг нийт дүнгээр баталж байна. Иймд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам"-ын 2.1-т заасан хугацааг төсвийн төсөл боловсруулах хугацаатай уялдуулан өөрчлөх арга хэмжээ авах саналыг Сангийн яам болон Хууль зүйн дотоод хэргийн яаманд хүргүүлэх
2. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах" журам 1998 онд батлагдсан байх бөгөөд хууль 2019 онд шинэчлэн батлагдсан байтал журам нь өнөөг хүртэл шинэчлэгдээгүй байна. Иймд дээрх журмыг шинэчлэн батлах, энэ журамд Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д заасан хөрөнгийг зарцуулах чиглэлийг илүү, тодорхой болгож журамлах шаардлагатай байна. *Тухайлбал:*
 - ✓ 46.5.4 дэх заалтад "....чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх" гэсэн заалт нь зөвхөн шүүхийн шинжилгээний байгууллагын хувьд хамааралтай юу, бусад гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хувьд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлж болох эсэх нь эргэлзээтэй байна.
 - ✓ 46.5.10 дахь заалт нь орон нутагт хамааралтай эсэхийг нарийвчлан тусгаж өгөх
 - ✓ 46.5.11. "хууль тогтоомжид заасан бусад" гэсэн заалтыг илүү тодорхой болгох.
3. Улсын төсвийн байгууллагуудын торгуулийн орлого улсын төсөв болон нийгмийн даатгалын санд төвлөрч байгаа нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь заалттай нийцэхгүй байгаа асуудлыг Сангийн яаманд уламжилж шийдвэрлүүлэх
4. Нэхэмжлэхийн дугаараар төлж байгаа торгууль нь ямар байгууллагын оногдуулсан торгууль төвлөрч байгаа нь тодорхой бус тул орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллага бүрээр гаргах боломжгүй байдал бий болж хяналт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгааг залруулах арга хэмжээ авах саналыг Сангийн яам, Татварын ерөнхий газарт уламжлах
5. Бүртгэлийн нэгдсэн сантай болох чиглэлээр арга хэмжээ авч ажиллах саналыг Засгийн газар, Сангийн яаманд уламжлах.

----- ooOoo -----



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ :



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА


Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2025.08.04 № 04/1096
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн “Хүү,
торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалт” сэдэвт
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Нэмэлт тайлбар санал байхгүй болно.

ОРЛОГЧ



Ч. БАТНАЙРАМДАЛ

652500400395



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ :



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 1131

Эрдэнэбулган сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн шийдвэрийг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор (П.Цэцэгдулам)-д үүрэг болгосугай.

4. Аудитын тайланд тусгагдсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА





Дарга, тэргүүлэх аудиторын 2025.08.04-ны
08.04 сарын 04 өдрийн 485/А0360217 дугаар
тушаалын хавсралт

“Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Хаана	Тоо	Мөнгөн дүн /сая.төгрөг/	Шийдвэр	Шийдвэрийн огноо, дугаар	Байгууллага албан тушаал
1	Аймгийн ИТХ	1	0.0	Албан шаардлага	2025.08.04 485/A0360217	ИТХ-ын дарга
2	Аймгийн Байгаль орчны газар	1	7.6	Албан шаардлага	2025.08.04 486/A0360217	Байгаль орчны газрын дарга
3	Аймгийн Цагдаагийн газар	1	436.9	Албан шаардлага	2025.08.04 487/A0360217	Цагдаагийн газрын дарга
ДҮН		3	444.5			